

## ТАНИЛЦУУЛГА

Хүнсний гол нэрийн барааны үнэ,  
2017 оны 12-р сарын 13-ны байдлаар


2017 оны 12-р сарын 13-ны байдлаар гол нэрийн барааны үнийг өмнөх сартай харьцуулахад 1.3 хувь, өмнөх 7 хоногтой харьцуулахад 0.3 хувиар буурсан байна.

**Махны дундаж үнэ:** 2017 оны 12-р сарын 13-ны байдлаар хонины ястай махны үнэ өмнөх сараас 3.8 хувь, үхрийн ястай махны үнэ 2.7 хувь, үхрийн цул махны үнэ 1.8 хувь, ямааны ястай махны үнэ 6.5 хувиар буурсан бол адууны ястай махны үнэ өөрчлөлтгүй байна.

Өмнөх 7 хоногтой харьцуулахад хонины ястай махны үнэ өмнөх сараас 0.7 хувь, үхрийн ястай махны үнэ 0.2 хувь, ямааны ястай махын үнэ 6.1 хувиар буурч, үхрийн цул мах болон адууны ястай махны үнэ өөрчлөлтгүй байна.

2017 оны 12-р сарын 13-ны байдлаар 1 кг хонины /ястай/ мах дунджаар 5175 төгрөг, үхрийн /ястай/ мах 6525 төгрөг, үхрийн цул мах 8015 төгрөг, адууны /ястай/ мах 4900 төгрөг, ямааны /ястай/ мах 3535 төгрөгийн үнэтэй байв (Зураг 1).

**Зураг 1.** Ястай махны жижиглэн худалдааны дундаж үнэ




**Гурилын үнэ:** 2017 оны 12-р сарын 13-ны байдлаар гурилын үнийг өмнөх сарынхтай болон өмнөх 7 хоногтой харьцуулахад өөрчлөлтгүй байна.

**Будаа, элсэн чихрийн дундаж үнэ:** 2017 оны 12-р сарын 13-ны байдлаар цагаан будааны үнэ өмнөх сар болон өмнөх 7 хоногийнхтой харьцуулахад өөрчлөлтгүй байна.

Элсэн чихрийн үнэ өмнөх сар болон өмнөх 7 хоногийнхтой харьцуулахад өөрчлөлтгүй байна. (Зураг2).

**Зураг 2.** Цагаан будаа, элсэн чихэр, төмсний дундаж үнэ



**Төмс, хүнсний ногооны дундаж үнэ:** 2017 оны 12-р сарын 13-ны байдлаар төмс, хүнсний ногооны үнийг өмнөх сарын дундаж үнэтэй харьцуулахад төмсний үнэ 4.7 хувь, Хүрэн манжин болон луувангийн үнэ 1.2 хувь, байцааны үнэ 0.6 хувь буурсан сонгины үнэ өөрчлөлтгүй байна.

Өмнөх 7 хоногийнхтой харьцуулахад төмс, хүнсний ногооны үнэ өөрчлөлтгүй байна.

**Сүү, өндөг, ургамлын болон цөцгийн тосны дундаж үнэ:** 2017 оны 12-р сарын 13-ны байдлаар сүүний үнийг өмнөх сарынхтай харьцуулахад, “Элекстер” /0.5 литрийн/ сүүний үнэ 1.1 хувь, савласан /1 литрийн/ сүүний үнэ 3.6 хувь, задгай сүүний үнэ 2.2 хувиар өссөн байна. Өмнөх 7 хоногийнхтой харьцуулахад задгай сүү болон “Элекстер” /0.5 литрийн/ сүүний үнэ өөрчлөлтгүй, харин савласан /1 литрийн/ сүүний үнэ 0.6 хувиар өссөн байна.

ургамлын тосны үнэ өмнөх сараас 0.5 хувиар өсч, цөцгийн тосны үнэ өмнөх сар болон өмнөх 7 хоногийнхтой харьцуулахад 1.8 хувиар өссөн байна.